

ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ ДАХЬ ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН БАРИМТЫН ТОЙМ

2008 оны 1-р сарын байдлаар Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Үндэсний архивын газрын харьяа Үндэсний төв архивт 1674 оноос өнөөг хүртэлх үеийн 1211 хөмрөгийн нийт 900000 гаруй хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

Сан хөмрөгийн баримтыг түүхэн үе болон баримтын онцлог шинжээр нь:

1. Манжийн үеийн 1674-1911
2. Богд хаант Монгол улсын үеийн 1911-1921
3. Ардын засгийн буюу 1921 оноос өнөөг хүртэлх үеийн
4. Кино дуу дүрсний
5. Шинжлэх ухаан, зураг төслийн гэж ангилж үздэг юм.

Үндэсний төв архив нь архивын тухай хуульд заасны дагуу Монголын ард түмний амьдрал, хөгжлийн түүхийг тусгасан түүх, эрдэм шинжилгээ, эдийн засаг, соёлын ач холбогдолтой баримтаар сан хөмрөгөө тогтмол баяжуулдаг бөгөөд 2002 онд Олон улс судлалын хүрээлэнгийн баримтыг эмхлэн цэгцэлж тус архивт хүлээн авчээ.

Олон улс судлалын хүрээлэнгийн баримт нь Үндэсний төв архивт байнга хадгалагдах баримтын тоонд орох бөгөөд Ардын засгийн буюу 1921 оноос өнөөг хүртэлх үеийн баримтад хамаарагдана.

Тус хүрээлэнгийн баримт нь Үндэсний төв архивын 467-р хөмрөгийг үүсгэн хадгалагдаж байгаа бөгөөд 2 данстай. 1949-2001 оныг хамарсан нийт 396 ширхэг хадгаламжийн нэгжээс бүрдэж байна.

Үндэсний төв архив дахь тэдгээр баримт бичгийг бүрдэл, онцлогоор нь:

Дэс/д	Баримтын ангилал	хн	Эзлэх хувь
1	ЭША-ын төлөвлөгөө тайлан	91	23.0
2	ЭША-ын хурлын протокол, тогтоол, удирдамж	90	22.7
3	Захиргаа, аж ахуйн тайлан, тэнцэл, бүртгэл, тушаал, протокол	62	15.6
4	Эрдэм шинжилгээний өгүүлэл, ном, товхимол	44	11.1
5	Гадаад, дотоодын хуралд тавьсан илтгэл	42	10.7
6	Танилцуулах мэдээ, мэдээлэл	38	9.6
7	Орчуулгын ном товхимол	22	5.5
8	Гэрээ, хэлэлцээр	7	1.8
	Бүгд	396	100%

Ерэн нэгэн хадгаламжийн нэгж нь хамгийн олон нь болох бөгөөд ЭША-ын төлөвлөгөө, тайлан байна. Энэ нь нийт хадгаламжийн нэгжийн 23 хувийг эзэлнэ.

Үүнтэй бараг ижил хувийг ЭША-ын хурлын протокол, тогтоол, удирдамж эзэлж байна.

Тус хүрээлэнгээс эрхлэн гаргасан эрдэм шинжилгээний өгүүлэл, ном товхимол, орчуулгын ном товхимол, гадаад дотоодын хуралд тавьсан илтгэл, танилцуулах мэдээ, мэдээлэл нь 146 хадгаламжийн нэгж болох бөгөөд нийт хадгаламжийн нэгжийн 36.9 хувийг эзэлж байна.

Үлдсэн хамгийн бага буюу 1.8 хувийг гэрээ, хэлэлцээр тус тус эзлэж байна.

Нийт баримтын 11.3 хувь буюу 45 хадгаламжийн нэгж нь гадаад хэл дээрх баримт байна. Гадаад хэл дээрх баримтын олонх нь орос хэлээр байгаа бөгөөд голдуу олон улсын эрдэм шинжилгээний хуралд зориулан тавьсан илтгэлүүд байна.

Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа Олон улс судлалын хүрээлэнгийн баримтын бүрдлийн тухай тоймлон хүргэхэд ийм байна.

*Бэлтгэсэн: О. Туяа /Үндэсний төв архивын
эрдэм шинжилгээний ажилтан/*